

МАНЖ ЧИН УЛСЫН ТҮҮХИЙН ЗАРИМ СУРВАЛЖ БИЧГҮҮД

Д. Наран

Монгол Улсын Их Сургууль, Гадаад Хэл Соёлын Сургууль, Хятад судлалын тэнхим.

Өгүүллийн товч утга: Манж Чин улсын түүхтэй холбогдох тулгуур сурвалж бичгүүд Чин улсын эзэрхийллийн үеийн Монголын түүх судлалд чухал хэрэглэгдэхүүн болох агаад уг өгүүлэлд тэдгээр сурвалжуудын бүтэц агуулга, судалгааны ач холбогдолтой байгаа мэдээ баримтуудыг тоймлон өгүүлэхийг зорьсон юм.

Түлхүүр үг: Түүхийн 1-р архив, Эзэн хаадын хэрэг явдлын товчоон, Чин улсын үнэн тэмдэглэл, Хуучин манж бичгийн дэвтэр, Нурхачи.

2001-2002 онд Хятадын соёл судлалын сангийн шугамаар Шанхай дахь Фүданий Их Сургуулийн Түүхийн факультетэд профессор багш Фань Шүжи-гийн удирдлага доор Чин улсын улс төрийн түүхийн талаар судалгааны ажил хийж мөн хугацаанд сургуулийн номын сан, Шанхай хотын номын сан, Бээжин дэх Түүхийн 1-р архивт хадгалагдаж буй манжийн түүхтэй холбогдох түүхэн сурвалж бичиг, судалгааны материалууд дээр ажиллах завшаан тохиолдсон билээ.

Хятадын газар нутаг дээр оршин тогтнож байсан төрт улсуудын дотор Манж Чин улстай холбогдох сурвалж бичгүүд хамгийн олон бөгөөд хятад хэлээр бичсэн ном, судлагдахуун, архивын баримт сэлт ариун их агаад бас манж, төвд, монгол, англи, герман, франц, португали, япон гэх бусад хэлний материалууд цөөнгүй байх ажээ. Эдгээр түүхэн сурвалжаас "Хуучин манж бичгийн дэвтэр"/"滿文老檔"/, Эзэн хаадын хэрэг явдлын товчоон/ "起居注"/, "Чин улсын үнэн тэмдэглэл" /"清实录"/, "Дунхуа тэмдэглэл" /"东华录"/, "Чин улсын судар"/"清史稿"/, "Юнлигийн үнэн тэмдэглэл" /"永历实录"/, "Сяньвангийн үнэн тэмдэглэл"/"先王实录"/, "Чин улсын нэвтэрхий бичиг" /"皇清通志纲要"/, "Юнсяний тэмдэглэл" /"永宪录"/ зэрэг нь нэлээд эмх цэгцтэй найруулан бичсэн судлагдахуун болно. "Хуучин манж бичгийн дэвтэр" /"滿文老檔"/, "Эзэн хаадын хэрэг явдлын товчоон", "Чин улсын үнэн тэмдэглэл" зэрэг нь Чин улсын талаар өргөн хүрээтэй баримт мэдээлэл агуулсан, судалгааны үнэ цэнэтэй судлагдахуун юм.

1. "Хуучин манж бичгийн дэвтэр" /"滿文老檔"/

Энэ бол манжууд Хятадыг эзлэхээс өмнөх үеийн хуучин манж бичгээр үйлдсэн он дарааллын бичиг юм. Гэвч бүрэн хадгалагдаж үлдсэнгүй. Эдүгээ анхны эхээрээ 40 боть байгаа бөгөөд ихэнх нь хуучин манж бичгээр бичсэн байна. Харин Тэнгэрийн тэтгэсэн хааны үед шинэ манж үсгээр хуулбарлан бичиж, нийт зургаан боть нэг зуун наян дэвтэр болжээ. Энэ судлагдахуун анхны эхээрээ Тайваний Тайбэй хотын Гугуны ордонд бий. Хуулбарууд нь Бээжин дэх Түүхийн нэгдүгээр архив, Ляонин мужийн Архивын газар бий. Уг архивт 1607 оноос 1636 оны хооронд болж өнгөрсөн үйл явдлуудыг он, сар, өдрийн дараалаар тэмдэглэсэн агаад манжууд Хятадыг эзлэн нэгтгэхээс өмнөх түүхийг судлахад чухал ач холбогдолтой. Мин улсын харьяат Зяньжоу газрын зөрчид аймгийн удирдагч Нурхач гучин жилийн дотор хэрхэн зөрчин аймгуудыг нэгтгэсэн, манж үндэстэн бүрэлдэн тогтсон, Ляоян, Шэньяныг хэрхэн эзлэн авсан, Мин улсын цэрэгтэй хэрхэн байлдаж ялсан, хэрхэн хүчирхэгжин Хожуу үеийн Алтан улсын эзэн хаан болсон, манжийн аж ахуй, үйлдвэрлэл, нийгмийн анги давхарга, цэрэг засаг төрийн тогтолцоо, алдар гавьяатай хүмүүс, дотоодын тэмцэл, зөрчил болон болж өнгөрсөн бусад чухал үйл явдлуудын тухай

дэлгэрэнгүй мэдээ бий. Жишээ нь: Нурхачаас 1619 оны 12-р сард мөн 1620 оны 4-р сард Халх аймагт хоёр удаа захидал илгээж эхнийхдээ монголчууд мал аж ахуй эрхэлдэг, хүнсэндээ мах хэрэглэдэг, арьс шир бэлтгэдэг, манжууд газар тариалан эрхэлж амуу будаа хүнсэндээ хэрэглэдэг тухай дурьдсан бол нөгөө нэг нь эзэн тэнгэр Нурхачид газар нутаг хайрласан тухай, ховор ан амьтны арьс, хөвөн, торго, алт, мөнгө зэрэг эд баялгаа монголчуудад гайхуулсан агуулгатай байна.¹ Мөн Хожуу Алтан улс байгуулагдсан цагийн анги, давхаргуудын харилцаа, нийгмийн эд баялгийг хуваарилдаг зарчим, нийгмийн тогтолцооны онцлог шинжүүдийг уг сурвалжаас судлаж болно. Ялангуяа манжийн төр улсын эхэн үеийн түүх, манж монголын XVII зууны эхэн үеийн харилцааг судлахад “Хуучин манж бичгийн дэвтэр” чухал хэрэглэгдэхүүн болно.

2. “Эзэн хаадын хэрэг явдлын товчоон”

Энх Амгалан хаан төр барих үеэс эхлэн Чин улсын хаадын албан ёсоор хэрэг явдал хөтлөх алба байгуулж, аажуудаа бичгийн хүн тавьж өдөр тутмынхаа үйл явдлын талаар тэмдэглэл хөтлүүлдэг журам тогтжээ. Үүнийг Энх амгалан хааны 9-р он буюу 1663 онд эхэлж Хэвт Ёсны 2-р он буюу 1911 он хүртэл хийжээ.² Гэвч үүнээс өмнө төрийн эрх түр барьж, явсан Дөргөн мөн ийм тэмдэглэл хөтлүүлж байсан юм. Чин улсын “Эзэн хаадын хэрэг явдлын товчоон” эдүгээ Бээжингийн Түүхийн 1-р архив, Тайбэйн Гугуны ордны архивт хадгалагдсаар буй. Нийт 3863 боть буй. “Энх Амгалан хааны хэрэг явдлын товчоон” 1984 онд хэвлэгдэн гарсан бөгөөд 2001 онд Шанхайн номын сан, Бээжингийн Түүхийн 1-р архивт байхыг миний бие олж үзэж монголтой холбогдох зарим зүйлүүдийн талаар тэмдэглэл хийсэн юм. Монгол манжийн ихэс дээдсийн харилцаа холбооны талаар, Энх Амгалан хаан монгол ноёдыг хүлээн авч, элбэг баян хурим найр хийсэн, Монголоос хэн хэн манжийн хаанд ёслол бараалхсан, Монголын талаар авч явуулсан бодлого, арга ухааны талаар судалгаа хийхэд ач холбогдолтой болно.³ Эзэн хааны нэгэн өдрийн бүх үйл амьдрал, ярьсан хийсэн зүйлийг нэг нэгэнгүй тэмдэглэхдээ тэдний гаргасан зарлиг тушаал, шийдвэрлэсэн гол гол асуудлууд, хүлээн авч уулзсан түшмэд ноёд, гүрний улс төрийн бодлого, тухайн үеийн нууц хэрэг явдал зэрэг мэдээ баримтууд бий.

3. “Чин улсын үнэн тэмдэглэл” нь Чин улсын түүхийг судлах гол сурвалж бичиг болно. Чин улсын эрх барьж байсан хаадын тухай тэмдэглэл бөгөөд эзэн хаан түүх бичлэгийн бүхэл бүтэн нэгж алба байгуулж бичгийн хүн тавьж нэг буюу хэд хэдэн хаадын бодит түүхийг бичүүлдэг байв. Уг бичигт Тайзу хаанаас эхлээд 12 үеийн хаадын үйл явдлын талаар өгүүлсэн. Нийт 4363 дэвтэр байна. Үүнд “Чингийн Гаозун хааны үнэн тэмдэглэл” хамгийн их, 1500 дэвтэр болно. Агуулгын хувьд нилээд баялаг, өргөн хүрээтэй. Улс төр, цэрэг дайн, эдийн засаг, соёл, үндэстэн, гадаад харилцаа, байгалийн үзэгдэл гэх мэт олон зүйлийн тухай мэдээлэл байна. Гэвч манжийн түүхийг илт магтан дөвийлгөх гэсэн Чингийн эзэн хаадын санаархлаас болж зарим түүхэн үнэн явдлыг засварласан, гуйвуулсан явдал бий. Уг сурвалж бичиг дэх Манжийн хаадын тухай тэмдэглэлүүд нь олон хэрэг явдлыг өгүүлэвч ерөнхийдөө агуулга, доторхи бүлэг зүйлийн талаар төстэй байна. Жишээ нь, “Чингийн Гаозун хуандийн үнэн тэмдэглэл” 200 гаруй хэрэг явдлыг өгүүлсэн, үүнд улс төр, цэрэг, эдийн засаг, соёл, үндэстэн, гадаад харилцаа, байгалийн үзэгдэл гэх мэт олон зүйлийн агуулгатай. Цэргийн хэрэг явдлын талаар Монголын түүхтэй холбоотой хэсэг

¹ Zhongguo Tongshi. Shanghai Renmin Chubanshe. 1999., 2-р тал

² Kangxi Qijuzhu. Beijing., 1984. 3-р тал

³ Мөн тэнд 47-р тал, 63-р тал

бол “Говийн умарт газрыг номхотгосон хэргийн товч” гэх бүлэг бидний сонирхлыг татах ёстой.¹

4. “Дунхуалу тэмдэглэл” /“东华录”/ 1616 он буюу Нурхачаас Найралт Тевийг төр барьж дуусталх түүхэн хугацааг хамарсан нийт 32 боть сурвалж бичиг бөгөөд Зян Лянци гэгч эмхтгэн найруулжээ. Бас Ван Сяньцянь гэгч хүний найруулсан “Дунхуалу тэмдэглэл” /“东华录”/, “Дунхуалу тэмдэглэлийн үргэлжлэл” гэж байх агаад 1616 оноос Бүрэн засагч хуандийн үеийн цаг хугацааг хамрдаг. Энэ хоёрыг нийлүүлж “9 хуандийн үеийн Дунхуа тэмдэглэл” ч гэдэг. Нийт 624 боть, Манж Чин улсын түүхийн зайлшгүй судлагдахуун болно.

5. “Чин улсын судар” /“清史稿”/ 1928 онд хэвлэгдсэн, нийт 529 боть. Монголын ноёд манжийн ихэс дээдэстэй найрамдаж ураг төрлийн холбоо тогтоосон, дагаар ирж орсон тухай мэдээ материал арвин бий. Жишээ нь, өөлдүүд манжид дагаар орсон, манж цэрэг Мингийн Нинюань руу довтолсон, тэдний бүрэлдэхүүн дэх монгол цэрэг Зюэхуа арлыг довтолж 2000 завь олзолсон..., цэрэг байлдааны үйл ажиллагаа, хошуу эзэнг томилсон гэх мэт олон мэдээ баримт бий.² Уг сурвалжид алдаа мадагтай зүйл нилээд байгаа, зарим тал дээр манжийн хаадын үйл хэргийг хэт дөвийлгөн магтсан зүйл байх ажээ.

6. “Гүрний харьяат аймгуудын тухай бичиг” /“皇朝藩部要略”/ бол монгол манжийн харилцааны талаар баялаг мэдээ баримттай. Үүнийг зохиогч нь Чин улсын судар бичгийн хүрээлэнгийн найруулан бичигч Ци Юнь архивын баримт бичиг, монгол ном судар, бусад түүхэн сурвалжийн мэдээнд тулгуурлан 8 жилийн дотор уг бүтээлээ бичжээ. Нийт 18 боть. Уг бүтээлд он цагийн дарааллыг баримтлан Өвөр Монгол ба Гадаад Монгол, Зүүнгар, Дорнод Түркестан Чин улсын эрхшээлд орсон, дээрх орнуудын ноёдод хэргэм цол олгож байсныг тодорхой өгүүлжээ.

7. “朔方备乘” (“Умарт хилийн бүрэн тэмдэглэл”). Хэ Цютао гэдэг хүн найруулан бичсэн, нийт 80 боть болно. Голчлон Чин улсын умарт хил хязгаар, Чин улс Орос улсын харилцааны асуудлыг хөндсөн. Гэхдээ уг сурвалжид “Шэн Ү Шүлюэ” /“Эзэн хаадын дайлаар мордсон бичиг”/ хэмээх хэсэг манж монголын харилцаа, ялангуяа Чин улсаас Гадаад Монголтой /Халх/ харилцаж байсан тухай эзэн хаадын гаргасан тушаал зарлигуудыг ашиглан өгүүлсэн байна.⁶ Манж Монголын эрт буюу 17-р зууны эхэн үеийн харилцааны асуудал манайд тусгайлан судлагдаагүй явсаар ирлээ. Иймд эдгээр сурвалж бичгүүдийг нарийвчлан нягталж үзвэл Монголын түүхтэй холбоотой, ялангуяа манж монголын харилцаа, монголчууд Чин улсын харьяанд орсон түүхэн учир шалтгааныг улам илүү гүнзгийрүүлэн судлахад ач холбогдолтой юм.

Abstract: This article gives introduction of some main historical sources connected with the history of Manchu state which is very valuable to make research on issues of Mongol and Manchu relations at the beginning of 17th century. As for these sources, Beijing's First Historical Archives contains the large number of documents written in Chinese and Manchu.

¹ Zhongguo Tongshi. . Shanghai Renmin Chubanshe. 1999., 6-р тал.

² Qingshigao. Beijing., 1928. 14-19-р тал.

⁶ Политика маньчжурской династии Цин в Южной и Северной Монголии в 17 в. Москва., 1974. 14-р тал

Ном зүй

1. Zhongguo Tongshi. №17. Shanghai Renmin Chubanshe. 1999. (Хятадын нэвтэрхий түүх)
2. Политика маньчжурской династии Цин в Южной и Северной Монголии в 17 в. Москва., 1974
3. Qingshigao. Beijing., 1928 (Чин улсын судар)
4. Kangxi Qijuzhu. Beijing., 1984 (Энх Амгалан хаан. Хэрэг явдлын товчоон) 101